



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2026/081/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэбулган хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalbaat@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 135  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Я.БАЯСГАЛАН ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хангай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлын онцлог хэсэг

Тус байгууллага нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2934 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 14,957.0 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

#### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,287,758.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 241,625.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,460,552.1 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 11,577.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд өөрийн хөрөнгөөр 35,176.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн газраас 3,499.1 мянган төгрөгийн нийт 38,675.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Эрүүл мэндийн газраас 19,362.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 78.9 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>409,808,838.03</b>	<b>294,774,698.30</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	11,577,291.53
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	11,577,291.53
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	11,577,291.53
31211	Төрийн сангийн харилцах	-	11,577,291.53
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	144,228,203.32	14,957,014.17
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	144,228,203.32	14,957,014.17
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	265,580,634.71	268,240,392.60
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	243,014,475.51	242,214,246.10
35110	Тусгай зориулалттай материал	96,878,808.43	95,978,576.40
35130	Эм боох материал	146,135,667.08	146,235,669.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22,566,159.20	26,026,146.50
35410	Бичиг хэргийн материал	3,033,277.00	2,689,577.00
35420	Аж ахуйн материал	13,228,762.70	13,550,850.00
35440	Түлш, шатах тослох материал	2,242,400.00	2,284,200.00
35450	Барилгын засварын материал	308,000.00	100,000.00
35460	Хүнсний материал	3,753,719.50	7,401,519.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>744,973,506.34</b>	<b>894,319,390.86</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	744,973,506.34	894,319,390.86
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	737,611,006.28	886,956,890.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	410,203,419.24	607,947,396.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,552,820.98)	(41,196,906.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	297,282,331.00	297,282,331.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,791,631.18)	(108,047,019.74)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	189,015,244.17	196,373,189.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	(102,192,542.87)	(98,627,317.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,972,439.40	43,955,588.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,357,432.50)	(10,762,371.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,509,408.98	32,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,362,500.06	7,362,500.06
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(937,499.94)	(937,499.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,800,000.00	6,800,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,154,782,344.37</b>	<b>1,189,094,089.16</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,145,951,214.37</b>	<b>1,189,094,089.16</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,145,951,214.37	1,189,094,089.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	611,535,526.03	611,535,526.03
51101	Өмч: - төрийн	611,535,526.03	611,535,526.03
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	483,495,374.63	526,638,249.42
51210	Өмнөх үеийн үр дүн	483,495,374.63	483,495,374.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	43,142,874.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,920,313.71	50,920,313.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,154,782,344.37</b>	<b>1,189,094,089.16</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,308,329,343.08</b>	<b>1,382,199,151.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>225,342,720.06</b>	<b>50,902,967.67</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	225,342,720.06	50,902,967.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	225,342,720.06	50,902,967.67
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	28,041,678.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	221,842,720.06	22,861,289.67
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,082,986,623.02</b>	<b>1,331,296,184.10</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	33,100,000.00	241,625,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,100,000.00	241,625,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,049,886,623.02	1,089,670,584.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,049,886,623.02	1,089,670,584.10
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,091,101,878.08</b>	<b>1,339,056,276.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,091,101,878.08</b>	<b>1,339,056,276.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,091,097,544.08	1,284,393,095.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	685,340,450.74	813,830,607.62
210101	Үндсэн цалин	358,885,533.06	455,615,721.42
210102	Нэмэгдэл	269,239,919.08	303,713,414.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,482,998.60	6,471,000.00
210104	Урамшуулал	52,732,000.00	48,030,472.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	97,905,100.00	101,496,700.00
210201	Тэтгэврийн даатгал	72,948,000.00	68,233,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,239,200.00	8,315,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,198,500.00	4,157,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,041,000.00	4,157,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,478,400.00	16,631,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38,515,766.00	36,568,642.00
210301	Гэрэл, цахилгаан	8,521,666.00	11,243,642.00
210302	Түлш, халаалт	29,942,500.00	25,273,400.00
210303	Цэвэр, бохир ус	51,600.00	51,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,280,709.60	78,328,520.80
210401	Бичиг хэрэг	3,912,100.00	7,709,200.00
210402	Тээвэр, шатахуун	33,482,600.00	30,639,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,072,000.70	6,137,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,782,500.00	1,770,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,031,508.90	16,310,600.00
210408	Бараа материал акталсны зардал	-	15,762,330.80
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	120,290,222.57	116,370,856.08
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	106,307,722.57	100,825,764.98
210502	Хоол, хүнс	13,982,500.00	15,545,091.10
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,527,500.00	38,905,800.00
210604	Урсгал засвар	15,317,500.00	38,905,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,976,300.00	3,390,700.00
210702	Дотоод албан томилолт	6,976,300.00	3,390,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,140,475.00	741,541.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	95,641.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	219,875.00	113,500.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	62,500.00	32,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,121,020.17</b>	<b>94,759,728.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,349,000.00	7,686,536.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,772,020.17	87,073,192.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,334.00</b>	<b>54,663,181.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>54,648,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	24,648,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	30,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>4,334.00</b>	<b>15,181.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,334.00	15,181.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>217,227,465.00</b>	<b>43,142,874.79</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>217,227,465.00</b>	<b>43,142,874.79</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>953,665,512.70</b>	<b>1,488,609,051.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,500,000.00</b>	<b>28,041,678.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,500,000.00</b>	<b>28,041,678.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	3,500,000.00	28,041,678.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	28,041,678.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>950,165,512.70</b>	<b>1,460,567,373.25</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>33,100,000.00</b>	<b>241,625,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,100,000.00	241,625,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>917,065,512.70</b>	<b>1,218,941,773.25</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	917,065,512.70	1,218,941,773.25
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>988,425,849.74</b>	<b>1,477,031,759.72</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>988,425,849.74</b>	<b>1,477,031,759.72</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>988,421,515.74</b>	<b>1,422,368,578.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>685,340,450.74</b>	<b>813,830,607.62</b>
210101	Үндсэн цалин	358,885,533.06	455,615,721.42
210102	Нэмэгдэл	269,239,919.08	303,713,414.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,482,998.60	6,471,000.00
210104	Урамшуулал	52,732,000.00	48,030,472.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>97,905,100.00</b>	<b>101,496,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,948,000.00	68,233,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,239,200.00	8,315,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,198,500.00	4,157,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,041,000.00	4,157,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,478,400.00	16,631,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,095,666.00</b>	<b>36,610,442.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,521,666.00	11,243,642.00
210302	Түлш, халаалт	22,522,400.00	25,315,200.00
210303	Цэвэр, бохир ус	51,600.00	51,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>52,866,700.70</b>	<b>56,047,881.10</b>

210401	Бичиг хэрэг	3,992,100.00	6,829,391.10
210402	Тээвэр, шатахуун	33,482,600.00	29,808,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,072,000.70	6,137,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,920,000.00	4,562,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,400,000.00	8,711,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>85,548,814.40</b>	<b>121,348,094.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,081,314.40	92,032,094.00
210502	Хоол, хүнс	14,167,500.00	19,176,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,300,000.00	10,140,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,281,508.90</b>	<b>280,636,077.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	36,451,000.00
210604	Урсгал засвар	20,281,508.90	244,185,077.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,976,300.00</b>	<b>3,390,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,976,300.00	3,390,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,140,475.00</b>	<b>741,541.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	95,641.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	219,875.00	113,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	62,500.00	32,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,266,500.00</b>	<b>8,266,536.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,266,500.00	8,266,536.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,334.00</b>	<b>54,663,181.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>54,648,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	24,648,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	30,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>4,334.00</b>	<b>15,181.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,334.00	15,181.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(34,760,337.04)</b>	<b>11,577,291.53</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(43,353,837.04)</b>	<b>11,577,291.53</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>11,577,291.53</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	483,495,374.63	1,145,951,214.37
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	483,495,374.63	1,145,951,214.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	483,495,374.63	1,145,951,214.37
Тайлант үеийн үр дүн	-	-	43,142,874.79	43,142,874.79

2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	526,638,249.42	1,189,094,089.16
---------------------------------------	----------------	---------------	----------------	------------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,552,639,900.00	1,477,016,578.72
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,552,639,900.00	1,477,016,578.72
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,497,991,900.00	1,422,368,578.72
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	814,424,700.00	813,830,607.62
210101	Үндсэн цалин	575,521,100.00	455,615,721.42
210102	Нэмэгдэл	155,583,000.00	303,713,414.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,395,200.00	6,471,000.00
210104	Урамшуулал	74,925,400.00	48,030,472.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	101,496,700.00	101,496,700.00
210201	Тэтгэврийн даатгал	68,233,500.00	68,233,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,315,800.00	8,315,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,157,900.00	4,157,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,157,900.00	4,157,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,631,600.00	16,631,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,625,600.00	36,610,442.00
210301	Гэрэл, цахилгаан	11,688,600.00	11,243,642.00
210302	Түлш, халаалт	23,617,000.00	25,315,200.00
210303	Цэвэр, бохир ус	1,320,000.00	51,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	68,002,700.00	56,047,881.10
210401	Бичиг хэрэг	8,762,500.00	6,829,391.10
210402	Тээвэр, шатахуун	29,808,000.00	29,808,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,204,000.00	6,137,190.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,600,000.00	4,562,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,628,200.00	8,711,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	171,531,300.00	121,348,094.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	140,975,900.00	92,032,094.00
210502	Хоол, хүнс	19,180,400.00	19,176,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,375,000.00	10,140,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	287,550,000.00	280,636,077.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,500,000.00	71,627,000.00
210604	Урсгал засвар	251,050,000.00	209,009,077.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,976,300.00	3,390,700.00
210702	Дотоод албан томилолт	6,976,300.00	3,390,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,261,300.00	741,541.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,550,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	95,641.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	113,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	129,300.00	32,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,123,300.00	8,266,536.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,123,300.00	8,266,536.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	54,648,000.00	54,648,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	54,648,000.00	54,648,000.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,648,000.00	24,648,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000,000.00	30,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,552,639,900.00	1,488,593,870.25
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	241,625,600.00	241,610,419.00
132001	Орон нутгийн төсвөөс	241,625,600.00	241,610,419.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,287,758,300.00	1,218,941,773.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,287,758,300.00	1,218,941,773.25
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	23,256,000.00	28,041,678.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,256,000.00	28,041,678.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>11,577,291.53</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	5.00
620004	Гэрээт ажилтан	-	4.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 241,334.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд 232,919.9 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

Тайлант онд үндсэн хөрөнгө дансанд дотоод эх үүсвэрээс худалдан авсан хөрөнгийг данс буруу бүртгэсэн, мөнгөн гүйлгээний зардал илүү бүртгэсэн, үр дүн зөрүүтэй илэрхийлсэн зэрэг 232,919.9 мянган төгрөгийн алдааг холбогдох дансад залруулан бүртгүүлэв.

Аудитаар залруулагдаагүй 10,621.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 2 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 10,621.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 15,542.4 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Хэвтэн эмчлүүлэгчийн орон хоногийн тоонд үндэслэн хүнсний материалын норм, нормативаас хянахад нормоос, илүү бараа материал мах/ зарцуулсан 795,0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, хоёрдугаар хавсралт “Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар”-т Хэрэглүүрийн гуравт “Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана”, Төсвийн захирагчийн үүрэгт “Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ”, 2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардалын тодорхойлолт”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

### **3.2 Албан шаардлага**

3.2.1. Тайлант онд эм боох материалыг сумын эргэлтийн эмийн сан болон тендерт шалгараагүй аж ахуйн нэгжүүдээс худалдан авалт хийсэн, тендерийн үнэ, шалгуур үзүүлэлт баримтлаагүй, аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой 3,250.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.”, ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээ болон гэрээний хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ

3.2.2. Эм боох бараа материалын ангилалд тусгай зориулалтын бараа материал бүртгэсэнээс эм боох материалын үлдэгдэл өндөр, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эмийн захиалга хийдэггүйгээс он дамжин зарцуулагдаагүй эмийн үлдэгдэл их, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, эм боох материалын зарлага бүртгэхдээ эхэлж авсанаа эхэлж зарлагадах аргыг хэрэглээгүй, эм боох материалын тооллого тооцоо хийж акт үйлдээгүйтэй холбоотой зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", Сангийн сайдын 2025 А/03 тушаал Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журмын хавсралтын 8 зүйлийн 8.2.-д “Бараа материал нь түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал, нөөцийн бараа, бусад бараа материал бүрдэнэ.”, 8.3.-д Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

### **3.3 Зөвлөмж**

3.3.1 Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин, байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал болох авто машины сэлбэг, авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан 6,576.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу

зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтийг зөрчсөн

Шийдвэрлэсэн нь. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

3.3.2 Үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 27 нэр төрлийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй, үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй хөрөнгө бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтын 10 дугаар зүйлийн 10.24-д “Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ”, 10.26--д “Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ”

Шийдвэрлэсэн нь: Дараа тайлангийн хугацаанд дээрх хөрөнгүүдийн элэгдлийг орлогод хүлээн авсан онуудаас эхлэн нөхөж тооцон холбогдох данс бүртгэлд залруулга хийх.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан буруу илэрхийлсэн	1	232,919.9			1	232,919.9	1	232,919.9				
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>232,919.9</b>			<b>1</b>	<b>232,919.9</b>	<b>1</b>	<b>232,919.9</b>				

**4.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй		3,250.0						3,250.0		
Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл" нийлүүлэх АА. ЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй.	1	0.00					1			
Эм боох бараа материалын үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй.	1	0					1	0		
Хээтэн эмчлүүлэгчийн орон хоногийн тоонд үндэслэн хүнсний материалын норм, нормативаас хянахад нормоос, илүү бараа материал мах/ зарцуулсан/	1	795.0	1	795.0						
Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	6,576.0							1	6,576.0
Санхүүгийн программд үндсэн хөрөнгө бүртгэхдээ ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 39 нэр төрлийн 42.5 сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй.	1	0							1	0
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>10,621.0</b>	<b>1</b>	<b>795.0</b>	<b>2</b>	<b>3,250.0</b>	<b>2</b>	<b>6,576.0</b>		